



“ЗООС ГОЁЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 4 сарын 25 өдөр

Дугаар 01/19

Улаанбаатар хот

*Компанийн 2013 оны жилийн эцсийн
тайлан тэнцэл батлах, ногдол ашгийн тухай*

“Зоос гоёл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит ХИХ хурлын Тооллогын комиссын тогтоол, санал хураалтын дүн, хурлын хэлэлцүүлгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Зоос гоёл” ХК-ийн 2013 оны жилийн эцсийн тайлан балансаарх нийт хөрөнгийн болон өр төлбөр, эзэмшигчдийн өмчийн дүнг 2’326’316.8 мянган төгрөг /үүнд эргэлтийн хөрөнгө 1’095’232.6 мянган төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 1’231’084.2 мянган төгрөг, богино хугацаат өглөг 104’169 мянган төгрөг, эзэмшигчдийн өмч 2’222’147.9 мянган төгрөг, хуримтлагдсан ашиг 751’765.3 мянган төгрөг/-өөр баталсугай.
2. “Компанийн хувьцааг нэгтгэх” төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2013 оны цэвэр ашгаас тухайн жилд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсүгэй.



ХУРЛЫН ДАРГА

М. Балжин

Ж.БИЛЭГТ



“ЗООС ГОЁЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 4 сарын 25 өдөр

Дугаар 02/19

Улаанбаатар хот

*ТУЗ-ын гишүүнийг сонгох, Компанийн
ТУЗ-ийн 2014 оны зардлын төсвийг батлах тухай*

“Зоос гоёл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит ХИХ хурлын Тооллогын комиссын тогтоол, санал хураалтын дүн, хурлын хэлэлцүүлгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Далрай овогтой Даваасамбууг 2014 оны 05-р сарын 01-ний өдрөөс эхлэн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 3 жилийн хугацаатайгаар сонгосныг баталсугай.
2. 2014 оны 5-р сарын 1-нээс 2015 оны 5-р сарын 1 хүртэлх ТУЗ-ийн гишүүдийн сарын цалинг тус бүр 250.0 мянган төгрөгөөр, даргын цалинг 300.0 мянган төгрөгөөр, нарийн бичгийн даргын цалинг 500.0 мянган төгрөгөөр, нийт ТУЗ-ийн жилийн цалингийн санг 37,632.0 мянган төгрөгөөр, бусад зардлын жилийн төсвийг 13,000.0 мянган төгрөгөөр, нийт жилийн төсвийг 50,632.00 мянган төгрөгөөр баталсугай.
3. Батлагдсан төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Ж.Билэгт/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.БИЛЭГТ